



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/25/НА-СТА-ТЕЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Д.Баярсайхан Утас: 51-261663 Цахим хаяг: bayarsaikhand@audit.gov.mn Аудитын менежер: Д.Энхдалай Утас: 51-260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn Ахлах аудитор: А.Даваадорж Утас: 51-261628 Цахим хаяг: davaadorja@audit.gov.mn Аудитор: Я.Марал-Эрдэнэ Утас: 51-261628 Цахим хаяг: maral-erdeneya@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	15
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	15
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	16
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	16
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17
3.5.1 Төсвийн төлөвлөлт	17
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	18
3.5.3 Нэмэлт төсөв	19
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	19
3.5.5 Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт	21
4. АУДИТЫН ТАЙЛАН	23
4.1 Ерөнхий зүйл	23
4.2 Материаллаг байдал	23
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	23
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	23
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	24
4.5. Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	25
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	26
5.1 Төлбөрийн акт	26
5.2 Албан шаардлага	27
5.3 Зөвлөмж	27
6. АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ	29

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НҮБ	Нэгдсэн Үндэстний байгууллага
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

Засгийн газрын IV байр, Бага тойруу-3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26-04-37, Факс: (976-51) 26 42 30
Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.04.24 № 1125
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хүний эрхийн Үндэсний Комиссын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийт 676.9 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс давсан, дангаараа болон нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Тайлант хугацаанд төсвийг зохистой удирдаагүйгээс авлага өр төлбөр үүсгэсэн, ажиллагчидтай холбоотой 10.8 сая төгрөг, байгууллагаас авах 203.6 сая төгрөг нийт 214.4 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй, бараа, ажил, үйлчилгээний төлбөрийн 213.6 сая төгрөг, хувь хүмүүст төлөх 98.8 сая төгрөг, ажиллагчидтай холбоотой 16.7 сая төгрөг, нийт 329.3 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй;
- Гэрээгээр гүйцэтгэсэн 17.5 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээний гэрээг дүгнэж акт үйлдээгүй, 111.7 сая төгрөгийн гэрээг төсвийн жил дамжуулан байгуулсан, 3.7 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулсан байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6, 14, 16, 70 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5, 13, 18, 20 дугаар заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн

бөгөөд зохистой байх, иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2024 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 7 чиглэл 40 заалт бүхий Улсын Их Хурлын 2025 оны 77 дугаар тогтоол батлагдаж, хэрэгжүүлэх чиг үүргийг Засгийн газарт даалгасан байна.

Бүс нутгийн улс орнууд ахмад настны эрхийг хангах, насжилтад бэлтгэхэд тулгамдсан асуудлуудаа тодорхойлж, үндэсний бодлого, стратегийг тодорхойлох, шинэчлэх, батлан хэрэгжүүлэх, Ахмадын эрхийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын хэрэгцээ шаардлагын талаар бүсийн хэмжээнд нэгдсэн ойлголтод хүрч, конвенцыг батлуулах үйл ажиллагааг дэмжих зорилгын хүрээнд “Ази Номхон далайн бүсийн орнуудын хамтын ажиллагааг төлөвлөх нь” хэлэлцүүлгийг 2025 оны 06 дугаар сарын 19, 20-ны өдөр Монгол Улсын төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын төлөөлөл, Ази, Номхон далайн бүс нутгийн Хүний эрх, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллийг оролцуулан зохион байгуулсан бөгөөд хэлэлцүүлэгт шаардлагатай нийт 74.6 сая төгрөгийг төсвөөс зарцуулсан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор “Хамтын эрх-Хариуцлага” сэдвийн хүрээнд “Хүний эрхийн Үндэсний Форум-2025” арга хэмжээг 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдөр төр, хувийн хэвшил, иргэний нийгэм, олон улсын байгууллага, орон нутгийн төлөөлөл, эрдэмтэн судлаачдын нийт 450 гаруй төлөөллийг оролцуулан амжилттай зохион байгуулсан бөгөөд арга хэмжээнд шаардлагатай нийт 88.0 сая төгрөгийн зардлыг төсвөөс зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Хүний эрхийн Үндэсний Комиссын 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 2 төсөл арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулж, шалгарсан 2 байгууллагатай гэрээ байгуулан, 1,799.6 сая төгрөгийн компьютер, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, 472.0 сая төгрөгийн 2 тээврийн хэрэгслийг худалдан авч, үндсэн хөрөнгийн дансанд тус тус бүртгэсэн. Мөн урсгал зардлын санхүүжилтээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулж, шалгарсан 14 байгууллагатай нийт 543.1 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээний гэрээ байгуулсан байна.

Бусад асуудал

Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд стратегийн 6 зорилго, 7 зорилтын хүрээнд 127 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 86.0 хувьтай гэж тайлагнасан байна.

Тайлант онд Хүний эрхийн үндэсний комисс нийт 1,461 гомдол, мэдээлэл хүлээн авч, өмнөх жилүүдтэй харьцуулахад шийдвэрлэсэн гомдлын тоо хамгийн өндөр түвшинд хүрсэн байна. Гомдлын агуулгын шинжилгээгээр шударгаар шүүлгэх эрхтэй холбоотой 495 (33.9 хувь), хөдөлмөрлөх эрхийн 307 (21.0 хувь), халдашгүй, чөлөөтэй байх эрхийн 175 (12.0 хувь), хүүхдийн эрхийн 72, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн 37 гомдол тус тус давамгайлсан нь хүний эрхийн зөрчил тодорхой салбаруудад төвлөрсөн, системийн шинжтэй байгааг илтгэж байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



С МАГНАЙСҮРЭН

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	246,859.8	362,052.1
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	72,450.6	-
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	72,450.6	-
31210	Төгрөг	72,450.6	-
31211	Төрийн сангийн харилцах	72,450.6	-
33	АВЛАГА	80,320.7	214,493.6
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	80,320.7	10,812.1
33500	Бусад авлага	-	203,681.5
33510	Байгууллагаас авах авлага	-	203,681.5
35	БАРАА МАТЕРИАЛ	94,088.5	147,558.5
35100	Түүхий эд материал	3,724.9	4,617.9
35110	Тусгай зориулалттай материал	3,724.9	4,617.9
35400	Хангамжийн материал	90,363.6	142,940.6
35410	Бичиг хэргийн материал	10,579.4	6,340.8
35420	Аж ахуйн материал	1,448.9	9,845.0
35430	Сэлбэг хэрэгсэл	15,011.5	76,029.1
35440	Түлш, шатах тослох материал	560.1	1,832.0
35470	Бусад хангамжийн материал	62,763.7	48,893.7
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,387,804.4	5,412,915.8
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,387,804.4	5,412,915.8
39200	Биет хөрөнгө	576,048.7	2,601,160.0
39201	Барилга, байгууламж, орон сууц	15,512.4	15,512.4
39202	Хуримтлагдсан элэгдэл	(775.6)	(1,809.8)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	140,195.0	612,195.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	(8,178.0)	(49,730.9)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	469,044.4	2,122,309.6
39206	Хуримтлагдсан элэгдэл	(179,211.1)	(376,703.0)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	226,718.9	329,824.7
39208	Хуримтлагдсан элэгдэл	(114,998.8)	(78,179.5)
39217	Ном	27,741.4	27,741.4
39300	Биет бус хөрөнгө	2,811,755.8	2,811,755.8
39303	Бусад биет бус хөрөнгө	2,811,755.8	2,811,755.8
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,634,664.2	5,774,967.9
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	30,002.3	329,362.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	30,002.3	329,362.4
41300	Өглөг	30,002.3	329,362.4
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	13,002.3	16,806.4
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	25,534.5
41360	Бусад өглөг	17,000.0	287,021.5
41361	Байгууллагад төлөх өглөг	17,000.0	188,169.1
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	98,852.4
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,604,661.9	5,445,605.5
51	Засгийн газрын хувь оролцоо	3,604,661.9	5,445,605.5
51100	Засгийн газрын оруулсан капитал	108,348.0	108,348.0
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	108,348.0	108,348.0
51200	Хуримтлагдсан үр дүн	3,487,413.8	5,337,257.6
51210	Өмнөх үеийн үр дүн	2,234,571.8	3,496,313.9
51220	Тайлант үеийн үр дүн	1,252,842.0	1,840,943.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	8,900.2	-
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,634,664.2	5,774,967.9

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	7,272,987.3	12,913,469.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,470,591.4	12,913,469.3
120	Нийтлэг татварын бус орлого	1,470,591.4	199,258.8
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,460,195.0	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,460,195.0	-
120009	Бусад орлого	10,396.4	173,630.9
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	24,356.1
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	1,271.9
122	Тусламжийн орлого	-	12,714,210.4
1221	Хандив тусламж /дотоод/	-	12,714,210.4
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	12,485,608.1
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	10,214,022.7
122112	Хөрөнгийн санхүүжилтийн орлого	-	2,271,585.4
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	228,602.3
122131	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	228,602.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,802,395.9	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,571,682.0	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,571,682.0	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	230,713.9	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	230,713.9	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	6,020,145.4	11,071,502.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,020,145.4	11,071,502.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,927,941.8	10,599,725.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,705,299.5	6,627,544.9
210101	Үндсэн цалин	2,179,961.5	3,858,141.0
210102	Нэмэгдэл	858,690.5	1,661,441.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	351,120.0	433,064.0
210104	Урамшуулал	253,503.2	620,949.4
210105	Гэрээт ажлын хөлс	62,024.3	53,949.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	475,071.9	798,967.0
210201	Тэтгэврийн даатгалын зардал	321,591.6	547,645.9
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	35,565.0	60,731.3
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	33,430.6	37,326.7
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	16,262.6	28,898.4
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	68,222.1	124,364.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	173,833.2	197,517.7
210304	Байрны түрээс	173,833.2	197,517.7
2104	Хангамж, бараа материалын зардал	390,323.7	506,468.0
210401	Бичиг хэрэг	23,641.3	33,325.3
210402	Тээвэр, шатахуун	199,605.5	198,935.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	51,148.5	55,495.1
210404	Ном, хэвлэл	101,588.9	199,445.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,339.5	19,266.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,067.6	15,408.0
210604	Урсгал засвар	23,067.6	15,408.0
2107	Томилолт, зочны зардал	334,107.6	463,940.4
210701	Гадаад албан томилолт	143,502.1	144,542.6
210702	Дотоод албан томилолт	190,605.5	281,702.1
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	37,695.7

**Хүний эрхийн Үндэсний Комиссын 2025 оны санхүүгийн тайлан,
Төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	334,529.6	839,496.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	270,470.4	737,988.7
210803	Даатгалын үйлчилгээ	-	6,867.9
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	242.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	57,885.5	87,880.3
210807	Газрын төлбөр	6,173.7	6,517.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	491,708.6	1,150,383.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	106,235.8	511,750.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	279,719.7	368,826.2
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	105,753.1	269,806.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	92,203.6	471,777.3
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	30,122.9	29,908.7
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	0.9
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	0.9
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	0.9
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	30,122.9	29,907.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	61,951.0	441,868.6
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	413,364.6
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	61,951.0	28,504.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	129.7	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	129.7	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	1,252,842.0	1,841,966.9
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	1,023.3
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	-	1,023.3
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	-	(1,023.3)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	1,252,842.0	1,840,943.6

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	5,832,973.7	12,887,841.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,396.4	12,887,841.3
120	Нийтлэг татварын бус орлого	10,396.4	173,630.9
120009	Бусад орлого	10,396.4	173,630.9
122	Тусламжийн орлого	-	12,714,210.4
1221	Хандив тусламж /дотоод/	-	12,714,210.4
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	12,485,608.1
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	10,214,022.7
122112	Хөрөнгийн санхүүжилтийн орлого	-	2,271,585.4
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	228,602.3
122131	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	228,602.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,822,577.3	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,571,682.0	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,571,682.0	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	250,895.3	-

Хүний эрхийн Үндэсний Комиссын 2025 оны санхүүгийн тайлан,
Төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	250,895.3	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,870,777.3	10,688,706.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,870,777.3	10,688,706.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,778,373.6	10,080,007.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,695,964.7	6,560,638.5
210101	Үндсэн цалин	2,159,221.6	3,821,338.9
210102	Нэмэгдэл	888,628.6	1,673,337.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	350,921.1	433,363.7
210104	Урамшуулал	248,790.1	583,102.0
210105	Гэрээт ажлын хөлс	48,403.2	49,496.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	461,995.6	794,666.6
210201	Тэтгэврийн даатгалын зардал	311,868.6	543,345.5
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	35,738.8	60,731.3
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	28,768.6	37,326.7
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	16,897.6	28,898.4
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	68,722.0	124,364.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	173,833.2	181,617.7
210304	Байрны түрээс	173,833.2	181,617.7
2104	Хангамж, бараа материалын зардал	392,310.9	496,565.9
210401	Бичиг хэрэг	26,369.9	35,397.8
210402	Тээвэр, шатахуун	200,165.6	174,526.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	51,148.5	55,495.1
210404	Ном, хэвлэл	98,970.5	188,509.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,656.3	42,637.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,183.0	15,408.0
210604	Урсгал засвар	24,183.0	15,408.0
2107	Томилолт, зочны зардал	334,107.6	463,722.9
210701	Гадаад албан томилолт	142,738.7	144,542.6
210702	Дотоод албан томилолт	191,368.9	281,484.6
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	37,695.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	316,901.9	719,889.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	251,233.6	619,551.8
210803	Даатгалын үйлчилгээ	-	6,867.9
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	242.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	59,494.6	86,710.3
210807	Газрын төлбөр	6,173.7	6,517.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	379,076.8	847,498.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	91,831.6	486,709.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	287,245.2	360,789.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	92,403.6	608,699.2
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	30,122.9	63,539.6
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	33,631.8
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	33,631.8
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	0.9

Хүний эрхийн Үндэсний Комиссын 2025 оны санхүүгийн тайлан,
Төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2131126	Нэмэлт санхүүжилтийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	33,630.9
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	30,122.9	29,907.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	62,151.0	375,109.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	346,605.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	62,151.0	28,504.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	129.7	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	129.7	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	170,050.6
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	170,050.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(37,803.6)	2,199,134.8
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	6,000.0	2,271,585.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,000.0	2,271,585.4
2200	Дотоод эх үүсвэрээр	6,000.0	2,271,585.4
222001	Тоног төхөөрөмж	-	2,271,585.4
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,000.0	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(6,000.0)	(2,271,585.4)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(43,803.6)	(72,450.6)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	116,254.2	72,450.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	72,450.6	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	108,348.0	8,900.2	2,229,626.1	2,346,874.2
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	4,945.8	4,945.8
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	108,348.0	8,900.2	2,234,571.8	2,351,820.0
9	Тайлант үеийн үр дүн	-	-	1,252,842.0	1,252,842.0
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	108,348.0	8,900.2	3,487,413.8	3,604,661.9
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	8,900.2	8,900.2
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	108,348.0	8,900.2	3,496,313.9	3,613,562.1
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(8,900.2)	-	(8,900.2)
19	Тайлант үеийн үр дүн	-	-	1,840,943.6	1,840,943.6
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	108,348.0	-	5,337,257.6	5,445,605.5

Хүний эрхийн Үндэсний Комиссын 2025 оны санхүүгийн тайлан,
Төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Итгэргөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	13,188,397,700.0	12,485,607,210.4	702,790,489.6	94.7
12	Татварын бус орлого	13,188,397,700.0	12,485,607,210.4	702,790,489.6	94.7
122	Тусламжийн орлого	13,188,397,700.0	12,485,607,210.4	702,790,489.6	94.7
122005	Төсвөөс санхүүжих	13,188,397,700.0	12,485,607,210.4	702,790,489.6	94.7
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,188,397,700.0	12,485,607,210.4	702,790,489.6	94.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,916,797,700.0	10,214,021,785.4	702,775,914.6	93.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,377,935,300.0	9,819,404,967.0	558,530,333.0	94.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,733,112,400.0	6,549,726,579.9	183,385,820.1	97.3
210101	Үндсэн цалин	3,049,335,100.0	3,821,338,948.2	(772,003,848.2)	125.3
210102	Нэмэгдэл	2,464,639,800.0	1,673,337,779.5	791,302,020.5	67.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	446,473,100.0	433,363,672.8	13,109,427.2	97.1
210104	Урамшуулал	757,675,600.0	572,190,041.2	185,485,558.8	75.5
210105	Гэрээт ажлын хөлс	14,988,800.0	49,496,138.2	(34,507,338.2)	330.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	841,639,100.0	793,302,608.3	48,336,491.7	94.3
210201	Тэтгэврийн даатгал	572,314,600.0	541,981,493.1	30,333,106.9	94.7
210202	Тэтгэмжийн даатгал	67,331,100.0	60,731,311.3	6,599,788.8	90.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	33,665,600.0	37,326,658.0	(3,661,058.0)	110.9
210204	Ажилгүйдлийн даатгал	33,665,600.0	28,898,369.3	4,767,230.7	85.8
210205	Эрүүл мэндийн даатгал	134,662,200.0	124,364,776.7	10,297,423.3	92.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	181,715,700.0	181,617,700.0	98,000.0	99.9
210304	Байрны түрээс	181,715,700.0	181,617,700.0	98,000.0	99.9
2104	Хангамж, бараа материалын зардал	532,064,400.0	477,932,404.9	54,131,995.1	89.8
210401	Бичиг хэрэг	40,912,400.0	31,764,370.0	9,148,030.0	77.6
210402	Тээвэр, шатахуун	190,657,300.0	174,526,194.0	16,131,106.0	91.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	53,976,000.0	55,495,147.9	(1,519,147.9)	102.8
210404	Ном, хэвлэл	203,549,700.0	173,509,069.0	30,040,631.0	85.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	42,969,000.0	42,637,624.0	331,376.0	99.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,408,000.0	15,408,000.0	-	100.0
210604	Урсгал засвар	15,408,000.0	15,408,000.0	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	467,706,600.0	460,722,897.0	6,983,703.0	98.5
210701	Гадаад албан томилолт	144,542,600.0	144,542,600.0	-	100.0
210702	Дотоод албан томилолт	285,468,300.0	278,484,597.0	6,983,703.0	97.6
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	37,695,700.0	37,695,700.0	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	783,636,500.0	592,784,343.9	190,852,156.1	75.6

**Хүний эрхийн Үндэсний Комиссын 2025 оны санхүүгийн тайлан,
Төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	678,515,000.0	492,447,048.0	186,067,952.0	72.6
210803	Даатгалын үйлчилгээ	7,465,700.0	6,867,908.0	597,792.0	92.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	747,700.0	242,000.0	505,700.0	32.4
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	86,746,300.0	86,710,271.9	36,028.1	100.0
210807	Газрын төлбөр	10,161,800.0	6,517,116.0	3,644,684.0	64.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	822,652,600.0	747,910,433.0	74,742,167.0	90.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	503,902,200.0	449,550,786.0	54,351,414.0	89.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	318,750,400.0	298,359,647.0	20,390,753.0	93.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	538,862,400.0	394,616,818.4	144,245,581.6	73.2
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	31,791,400.0	29,907,818.4	1,883,581.6	94.1
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	31,791,400.0	29,907,818.4	1,883,581.6	94.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	507,071,000.0	364,709,000.0	142,362,000.0	71.9
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	418,632,000.0	346,605,000.0	72,027,000.0	82.8
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	70,335,000.0	-	70,335,000.0	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,104,000.0	18,104,000.0	-	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,271,600,000.0	2,271,585,425.0	14,575.0	100.0
222001	Тоног төхөөрөмж	2,271,600,000.0	2,271,585,425.0	14,575.0	100.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	179	171	8	95.5
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	0	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	89	85	4	95.5
620001	Удирдах ажилтан	7	7	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	75	75	0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	7	3	4	42.9
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	89	85	4	95.5
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	73	75	(2)	102.7
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9	3	6	33.3
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7	7	0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	-	228,602,308.43
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	228,602,308.43
122	Тусламжийн орлого	-	228,602,308.43
1221	Хандив тусламж /дотоод/	-	228,602,308.43
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	228,602,308.43

Хүний эрхийн Үндэсний Комиссын 2025 оны санхүүгийн тайлан,
Төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	228,602,308.43
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	228,602,308.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	228,602,308.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	228,602,308.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	10,911,952.27
210104	Урамшуулал	-	10,911,952.27
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	1,363,993.91
210201	Тэтгэврийн даатгал	-	1,363,993.91
2104	Хангамж, бараа материалын зардал	-	18,633,460.28
210401	Бичиг хэрэг	-	3,633,460.28
210404	Ном, хэвлэл	-	15,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	3,000,000.00
210702	Дотоод албан томилолт	-	3,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	127,104,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	127,104,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	67,588,101.97
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,158,223.17
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	62,429,878.80

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хүний эрхийн Үндэсний Комиссын эрхэм зорилго нь “Хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хамгаалах, хөхүүлэн дэмжих, хүний эрхийн соёлыг түгээх замаар хүн бүр эрх чөлөөтэй, эрх тэгш амьдрах, хөгжих нийгмийг цогцлоон бүтээхэд манлайлагч байх” гэж тодорхойлсон бөгөөд үндсэн чиг үүргийг дараах байдлаар хэрэгжүүлдэг байна. Үүнд:

- Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой аливаа асуудлаар санал, зөвлөмж гаргаж, эрх бүхий байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдэд хүргүүлэх;
- Хууль тогтоомж, захиргааны байгууллагын шийдвэрийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, хүний эрхийн үндсэн зарчимд нийцэж байгаа эсэх талаар санал гаргах;
- Хүний эрхийн талаарх олон улсын гэрээнд нэгдэн орох, соёрхон батлах эсэх талаар санал хүргүүлэх, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Зөвлөл болон гэрээний хороодод мэдээлэл хүргүүлэх;
- Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбогдсон хууль тогтоомжийг боловсронгуй болгох тухай саналаа хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжлах;
- Хүний эрхийн боловсролыг дэмжих, түгээх;
- Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах;
- Хүний эрхийн асуудлаар төр, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллага, хуулийн этгээд болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах;
- Шаардлагатай асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, ашгийн төлөө бус хуулийн этгээдээр судалгаа хийлгэх, тухайлсан асуудлаар мэргэшсэн шинжээч томилж, дүгнэлт гаргуулах;
- Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;
- Хүний хувийн мэдээлэл хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;
- Төрийн байгууллага, албан тушаалтан хүний эрхийг хангах, хамгаалах, хүндэтгэх үүргийн хэрэгжилтэд энэ хууль болон бусад хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд хяналт тавих;
- Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл боловсруулж, Улсын Их Хуралд хүргүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Комисс нь санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай хуулийг мөрдлөг болгон ажиллаж, Монгол Улсын хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон бусад холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

Тайлант хугацаанд үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль - нэмэлт, өөрчлөлт оруулах тухай,
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль – нэмэлт, өөрчлөлт оруулах тухай,
- Төрийн албаны тухай хууль – нэмэлт оруулах тухай,

Хүний эрхийн Үндэсний Комиссын 2025 оны санхүүгийн тайлан,
Төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

- Улсын Их Хурлын 2025 оны “Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2024 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 77 дугаар тогтоол.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Хүний эрхийн Үндэсний Комисс нь хяналт-шинжилгээ, үнэлгээ болон дотоод аудитын бие даасан хэлтэс, нэгжгүй бөгөөд чиг үүргийг Захиргаа, удирдлагын хэлтэст хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах референт, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэст төсөв, дотоод аудит хариуцсан референт тус тус гүйцэтгэж байна. Тайлант онд Тамгын газрын даргын баталсан дотоод аудитын төлөвлөгөөний дагуу дараах хяналт-шинжилгээ, үнэлгээ болон дотоод аудитын ажлуудыг зохион байгуулж, үр дүнг удирдлагадаа танилцуулсан байна. Үүнд:

- Хүний эрхийн Үндэсний Комисст ирсэн албан бичгийн шийдвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ;
- Мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ;
- Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах чиглэлээр хэрэгжүүлэх 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ;
- Албан хаагчдын 2025 оны сургалт, хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ;
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод аудит;
- Комиссын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийсэн байна.

Дээрх хэрэгжүүлсэн үйл ажиллагаатай танилцаж, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний үр дүнг аудитад ашигласан.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүний эрхийн Үндэсний Комиссын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хүний эрхийн үндэсний комиссын даргын 2020 оны А/19 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь холбогдох хууль, эрх зүйн үндэслэлд хүчин төгөлдөр бус болсон эрх зүйн баримт бичгүүдийг ашигласан хэвээр байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хүний эрхийн Үндэсний Комиссын 2025 оны санхүүгийн тайланг УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,140.3 сая төгрөгөөр буюу 58.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1

**Хүний эрхийн Үндэсний Комиссын 2025 оны санхүүгийн тайлан,
Төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Мөнгөн хөрөнгө	72.5	-	(72.5)
Авлага	80.3	214.5	134.2
Бараа материал	94.1	147.6	53.5
Үндсэн хөрөнгө	3,387.8	5,412.9	2,025.1
Нийт хөрөнгө	3,634.7	5,775.0	2,140.3
Өр төлбөр	30.0	329.4	299.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,604.7	5,445.6	1,840.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,634.7	5,775.0	2,140.3

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 72.5 сая төгрөгөөр буурсан нь Ахмадын сангийн харилцах дансны үлдэгдэл буурснаас шалтгаалсан;
- Авлагын дансны үлдэгдэл 134.2 сая төгрөгөөр өссөн нь нэмэлт санхүүжилт буюу донор байгууллагаас олгох санхүүжилтийн зарцуулах эрх Сангийн яамнаас нээгдээгүйгээс шалтгаалсан авлага 203.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн;
- Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 53.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд нийт 539.5 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 486.0 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан;
- Тайлант онд үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 2,025.1 сая төгрөгөөр өссөн нь Хүний эрхийн Үндэсний Комиссын 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн 2 төсөл, арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулж, гэрээний дагуу 1,799.6 сая төгрөгийн компьютер, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил, мөн 472.0 сая төгрөгийн тээврийн хэрэгслийг худалдан авч үндсэн хөрөнгөнд бүртгэсэн;
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 537 дугаар тогтоолын дагуу 51.5 сая төгрөгийн өртөг бүхий хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, үнийг 15.5 сая төгрөгөөр шинэчлэн тогтоосон, түүнчлэн 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн А1/2171 тоот албан бичгийн дагуу НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн төслийн хүрээнд 13.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг нэмэгдүүлэн бүртгэсэн нь үлдэгдлийн өөрчлөлтөд нөлөөлсөн байна. Мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 559 дүгээр тогтоолоор 20.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан байна.
- Өглөгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 299.4 сая төгрөгөөр өссөн нь ажил гүйцэтгэх гэрээний дагуу нийт 21 байгууллагаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт төлөх өр төлбөр 188.1 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой түрээсийн төлбөрт төлөх 1.1 сая төгрөг, бараа үйлчилгээний зардлын өглөг 24.4 сая төгрөг, хувь хүмүүст төлөх өглөг 98.8 сая төгрөг, ажилчидтай холбоотой 16.7 сая төгрөгийн цалин, НДШ-ийн өглөг тус тус нэмэгдсэнтэй холбоотой;
- Засгийн газрын хувь оролцоо данс нь тайлант үеийн үр дүн 1,840.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 30,603.2 сая төгрөгийг авч зарцуулахаар тооцон төлөвлөж Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас хөрөнгийн зардлыг 16,124.1 сая төгрөг, урсгал зардлыг 1,290.7 сая төгрөгөөр бууруулж, 13,188.4 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь хөрөнгийн зардалд төлөвлөсөн 18,005.7 сая төгрөгийн барилга байгууламж, их засварын зардлын

Хүний эрхийн Үндэсний Комиссын 2025 оны санхүүгийн тайлан,
Төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

тооцоолол бодит нөхцөлд нийцээгүй, хангалттай үндэслэл, тооцоонд тулгуурлан боловсруулаагүйтэй холбоотой байна.

Төсвийн тодотголоор хөрөнгийн зардлыг 2,271.6 сая төгрөг, урсгал зардлыг 10,916.8 сая төгрөгөөр хэвээр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр, батлагдсан төсвийн дагуу улсын төсвөөс 12,485.6 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал зардалд 10,214.0 сая төгрөг, хөрөнгийн зардалд 2,271.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 12,485.6 сая төгрөг буюу 94.7 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшилын зардал 183.4 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал 48.3 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал 54.1 сая төгрөгөөр, томилолт, зочны зардал 6.9 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 190.9 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	9,392.9	9,045.8	347.2	96.3
2	80226	Байр ашиглалтын үйлчилгээ	162.7	146.6	16.1	90.1
3	80509	ОУ-ын байгууллагын гишүүнчлэл хураамж	31.8	29.9	1.9	94.1
4	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	507.1	364.7	142.4	71.9
5	81565	Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа	213.2	204.0	9.2	95.7
6	81569	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	609.1	423.0	186.1	69.5
7	80918	Бусад /хөрөнгө оруулалт/	2,271.6	2,271.6	0.0	100.0
Нийт дүн			13,188.4	12,485.6	702.8	94.7

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас судалгаа авч, үр дүнг тусгалаа. Үүнд:

1. Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2025 оны А/43 дугаар тушаалаар комиссын бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн баталж, батлагдсан 91 орон тоог 9 хувь буюу 8 орон тоогоор цомхотгож, байгууллагын бүтцийг 8 хэлтэс 2 тасагтай байхаар төсөвт нийцүүлэн өөрчилсөн байна. Комиссын 2025 оны төсөвт цалингийн зардлыг 7,393.9 сая төгрөгөөр баталсныг тодотголоор 660.8 сая төгрөгөөр бууруулсан байна.

2. Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2025 оны А/123 дугаар тушаалаар комиссын ажилтнуудад олгох хоол, унааны хөнгөлөлтийн хэмжээг баталж, нэг ажилтанд ногдох хоолны хөнгөлөлтийг 30.0 мянган төгрөг, унааны хөнгөлөлтийг 2.0 мянган төгрөгөөр тогтоосон байна. Тайлант онд хоол, унааны хөнгөлөлтийн зардалд 446.4 сая төгрөгийн төсөв батлагдсан бөгөөд 433.3 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

3. Тайлант онд батлагдсан төсвөөс нийт 19 удаагийн төлөвлөгөөт гадаад томиллод 144.5 сая төгрөг, 1 удаагийн гадаад зочин төлөөлөгч хүлээн авах арга хэмжээнд 37.7 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

4. Мөн Хүний Эрхийн Үндэсний Комиссоос хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, төр болон иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор олон талт арга хэмжээ, хэлэлцүүлэг, сургалт, уулзалт, судалгааны ажлуудыг зохион байгуулсан. Үүнд:

- Хүний эрх ба хууль сахиулах ажиллагаа, Хүний эрх хамгаалагчийн эрхийн хэрэгжилт, Сонгуулийн үеийн хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Жагсаал, цуглаан дахь хүний эрхийн ажиглалт, Хүний хувийн мэдээлэл хамгаалах үйл ажиллагааны сэдвээр нийт 5 удаагийн сургалт зохион байгуулж, 21.9 сая төгрөгийг зарцуулсан.
- Хүний эрхийн 24 дэх илтгэлтэй холбоотой хэлэлцүүлгүүд, Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн судалгаа, Хүний эрхийн үндэсний индекс боловсруулах ажил, Олон нийтийн сүлжээний зохицуулалтын судалгаа, Өмгөөлөгч, сэтгүүлчдийн нөхцөл байдал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд гэрч, хохирогчийг хамгаалах, эрүү шүүлтийн хохирол нөхөн төлүүлэх, Гэмт хэрэг үйлдэгчийн сэтгэцийн байдлын үнэлгээ, Камерын хяналт ба хүний эрх, Нийгмийн зорилтот бүлэгт чиглэсэн Хүүхдийн эрх хамгаалах марафон, Ахмад настны эрхийн хэлэлцүүлэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, Эмэгтэй дипломатчидтай уулзалт хэлэлцүүлэг зэрэг нийт 22 удаагийн төлөвлөгөөт арга хэмжээ зохион байгуулж, 107.7 сая төгрөгийг зарцуулсан. Мөн бусад цаг үеийн шинжтэй нийт 323 удаагийн сургалт, хурал, зөвлөгөөн, түүнтэй адилтгах арга хэмжээг зохион байгуулсан байна.

5. Тайлант онд үндсэн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зорилгоор нийт 42 байгууллагатай ажил гүйцэтгэх гэрээ байгуулж 231.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

6. Биет бус хөрөнгөд нийт 47.2 сая төгрөгийн анхны өртөг бүхий 17 нэр төрлийн программ хангамж ашиглагдаж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 262.2 сая төгрөгийн эх үүсвэр төвлөрсөн бөгөөд үүнд Английн Элчин сайдын яамнаас 41.8 сая төгрөг, Австралийн Элчин сайдын яамнаас 130.8 сая төгрөг, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 25.5 сая төгрөг, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрөөс 2.0 сая төгрөг, Ази, Номхон далайн бүсийн форумас 17.2 сая төгрөг, НҮБ-ын Суурин зохицуулагчийн газраас 17.9 сая төгрөг, Монголбанкнаас 8.0 сая төгрөг, Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газрын “Нутгийн дэм” хөтөлбөрөөс 4.9 сая төгрөг, “Тэгш нийгэм” төрийн бус байгууллагаас 3.0 сая төгрөг, мөн хүний эрх хамгаалагчийн эрхийн хэрэгжилтэд мониторинг хийх төслөөс 11.0 сая төгрөг тус тус бүрдүүлсэн байна.

Дээрх эх үүсвэрийн хүрээнд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж, үүнээс цалин хөлс, нэмэгдэл урамшуулал болон ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардалд 12.3 сая төгрөг, хангамж, бараа материалын зардалд 18.6 сая төгрөг, албан томилолт, зочны зардалд 3.0 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 127.1 сая төгрөг, бараа, үйлчилгээний бусад зардалд 67.6 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2024 оны А/34 дүгээр тушаалаар төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг баталсан байна. Уг төлөвлөгөөнд төсвийн хөрөнгө оруулалтын 2,712.0 сая төгрөг, урсгал төсвийн 844.0 сая төгрөг, нийт 3,556.0 сая төгрөгийн санхүүжилтээр 18 нэр төрлийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар тусгасан байна. Комиссын даргын 2025 оны А/35 дугаар

Хүний эрхийн Үндэсний Комиссын 2025 оны санхүүгийн тайлан,
Төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

тушаалаар худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Батлагдсан төлөвлөгөөний дагуу нийт 25 удаагийн нээлттэй тендер шалгаруулалт зохион байгуулснаас 16 тендер шалгаруулалт амжилттай хэрэгжиж, шалгарсан аж ахуйн нэгж, байгууллагуудтай гэрээ байгуулан нийт 2,814.7 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан байна. Үүнд:

Хүснэгт 3. Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/сая төгрөгөөр/

Д/д	Тендер шалгаруулалтын нэр	Тендер шалгаруулалтын арга, зохион байгуулагч	Шалгарсан байгууллага	Гэрээний дүн
1	И-Монголия систем, иргэний бүртгэлийн цахимжилт дахь хүний эрхийн эрсдэлийн үнэлгээ	ХА, ХЭҮК	Өмгөөллийн ПрайсуотэрхаусКү үпэрс Лeгал ХХН	49.9
2	"Хүний эрхийн мэдрэмжтэй хот төлөвлөлт" нөлөөллийн ажил	ХА, ХЭҮК	Энхнахиа ХХК	24.0
3	"Ахмадын олон улсын форум" зохион байгуулах ажил	ХА, ХЭҮК	Блю Скай Эйжиа ХХК	74.6
4	Мэдээлэл технологийн үйлчилгээ-Office 365	ХА, ХЭҮК	Инфосолюшн ХХК	37.7
5	"Хүний эрх хамгаалагчдын эрхийн хэрэгжилт" судалгааны ажил	ХА, ХЭҮК	Оюуны Инноваци НҮТББ	30.0
6	"Дотоодын шилжилт хөдөлгөөн, шилжин суурьшигчдад тулгамдсан хүний эрхийн асуудал" судалгааны ажил	ХА, ХЭҮК	Бодлогын Инноваци ХХК	28.0
7	Эрүүл мэндийн байгууллагын тогтолцоо, эмч, эрүүл мэндийн ажилтны хөдөлмөрлөх эрх, ёс зүйн асуудал	ХА, ХЭҮК	Мэргэжлийн Социологчдын Холбоо НҮТББ	25.0
8	"Мэдэх эрх, нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт" судалгааны ажил	ХА, ХЭҮК	Цогц Хөгжлийн Үндэсний Төв	18.0
9	Монгол Улсын Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл англи хэлрүү орчуулах	ХА, ХЭҮК	МКМИ ХХК	27.1
10	Хүний эрхийн талаар контент бүтээх	ХА, ХЭҮК	Монголын Сошиал Нэгдэл НҮТББ	46.2
11	Монгол Улсын Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлийн сурталчилгаа, нөлөөллийн ажил	ХА, ХЭҮК	Монголын Сошиал Нэгдэл НҮТББ	27.3
12	Монгол Улсын Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл, бусад ном товхимол, сэтгүүл хэвлэх	ХА, ХЭҮК	Адмон Принт ХХК	69.4
13	"Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, хангамж бэлэн байдал" судалгааны ажил	ХА, ХЭҮК	МХИС	53.0
14			МХИС	33.0
15	Хүний эрхийн Үндэсний Комиссын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ Багц 1:Компьютер, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга	Нээлттэй арга, ТХААГ	Голденхоул ХХК	1,799.6
16	Хүний эрхийн Үндэсний Комиссын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ Багц 2:Албан хэрэгцээний автомашин	Нээлттэй арга, ТХААГ	Таванбогд ХХК	472.0
Нийт дүн				2,814.7

3.5.5 Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн хавсралтаар баталсан тус төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд 8 арга хэмжээний зорилтот түвшнийг тусгажээ.

Тайлант онд Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгасан 1 хөтөлбөр, 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж ажилласнаас биелэлт 100.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Үүнд:

Хүснэгт 4. Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

Д/д	Дэд дугаар	ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Хэмжих нэгж	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Хувь
70409 Хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих								
7.1	7.1.1	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлнэ.	7.1.1.1	Хүргүүлэх илтгэл	тоо	1	1	100.0
	7.1.2	Хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн асуудлаарх гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэнэ.	7.1.2.1	Гомдол шийдвэрлэлт	хувь	96	96	100.0
	7.1.3	Хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн асуудлаарх хяналт шалгалт зохион байгуулна.	7.1.3.1	Хяналт шалгалт	тоо	130	130	100.0
	7.1.4	Комиссын зөвлөмж, гишүүний шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавина.	7.1.4.1	Зөвлөмж, шаардлага	хувь	90	90	100.0
	7.1.5	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, Хүний хувийн мэдээлэл хамгаалах, Нийтийн мэдээллийн ил тод байдлын, Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавина.	7.1.5.1	Хууль тогтоомжийн хэрэгжилт	тоо	4	4	100.0
	7.1.6	Хүний эрхийн боловсролыг дэмжиж, түгээн дэлгэрүүлнэ.	7.1.6.1	Сургалт	цаг	500	500	100.0
	7.1.7	Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг Улсын Их Хуралд хүргүүлнэ.	7.1.7.1	Тайлан	тоо	1	1	100.0
	7.1.8	Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай зөвлөмжийн биелэлтийг хангуулна.	7.1.8.1	Зөвлөмжийн хэрэгжилт	тоо	1	1	100.0

Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, гүйцэтгэлээс үзэхэд, хүний эрхийн зөрчлийг илрүүлсний дараах засах арга хэмжээнд төвлөрсөн удирдлагын загвар давамгайлж, урьдчилан сэргийлэх, эрсдэлд суурилсан төлөвлөлтийн тогтолцоо сул хэвээр байна. Ялангуяа хүүхдийн эрхийн 72 гомдол, хөдөлмөрлөх эрхийн 307 гомдол, хувийн мэдээлэл хамгаалахтай холбоотой 100 гаруй зөрчилд суурилсан шаардлага, зөвлөмжүүд давтамжтайгаар гарч холбогдох төрийн байгууллагууд дотоод хяналт, ёс зүйн удирдлагаа хангалттай хэрэгжүүлж чадахгүйд хүрч байна.

Хүний эрхийн Үндэсний Комиссын 2025 оны санхүүгийн тайлан,
Төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Түүнчлэн 2025 онд Комиссоос 26 шаардлага, 70 зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийг холбогдох байгууллагууд “биелүүлсэн” гэж тайлагнасан хэдий ч ижил төрлийн хүний эрхийн зөрчил давтамжтайгаар дахин илэрч, хүний эрхэд суурилсан бодлого, хариуцлагын тогтолцоо бодит үр дүн авчрахуйц түвшинд бүрэн хэрэгжихгүй байна.

Иймд хүний эрхийн зөрчлийн эрсдэл өндөртэй шүүх, хууль сахиулах байгууллага, боловсрол, хөдөлмөр болон цахим орчны салбаруудад хүний эрхийн хэрэгжилтийн бодит үр нөлөөг үнэлэх зорилгоор гүйцэтгэлд суурилсан хяналт-үнэлгээ, тоон болон чанарын шалгуурт тулгуурласан үнэлгээ, мөн үр дүнгийн тасралтгүй мониторингийг гүйцэтгэл, нийцлийн аудитын хүрээнд хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хүний эрхийн Үндэсний Комиссын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн санхүүгийн үйл ажиллагаа нягтлан бодох бүртгэлийг сайжруулах, нягтлан бодох бүртгэлийн бодлогыг баримт бичгийг одоогийн мөрдөгдөж буй хууль тогтомж, стандарттай нийцүүлэн шинэчлэх, албан томилолтын зардлын төсвийг эрх бүхий албан тушаалтнаар батлуулж хэвшүүлэх, төсвийг зохистой удирдаж өр, авлага үүсгэхгүй байх талаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор А.Даваадорж, аудитор Я.Марал-Эрдэнэ нар гүйцэтгэж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Д.Энхдалай, Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Баярсайхан нар тус тус хэрэгжүүлсэн.

Хүний эрхийн Үндэсний Комиссын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 01/694 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 6,020.1 сая төгрөгөөс 1 хувиар буюу 60.2 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан хуулиар хориглосон, хязгаарласан гар утасны зардал, хэвлэл захиалгын төлбөр, цахим худалдан авалт арга хэмжээг тайлант онд санхүүжүүлээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хүний эрхийн Үндэсний Комисс нь тайлант онд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Тайлант онд Комиссын даргын баталсан гадаад томилолтын 10, Тамгын газрын даргын баталсан гадаад томилолтын 10, дотоод томилолтын 79, нийт 99 томилолтын тушаал батлагдсан байна. Үүнээс 71 тушаалд томилолтын зардлын төсөв урьдчилан батлагдаагүй байна.

Хяналт-шинжилгээнээс үзэхэд албан томилолтын байр, хоол, унааны зардлын төсвийг эрх бүхий албан тушаалтан урьдчилан баталж, батлагдсан төсөвт үндэслэн олгох шаардлагыг хангаагүй, томилолтын зардлын төлөвлөлт, төсвийн сахилга, санхүүжилтийн хяналт сул үр ашиггүй зарцуулалт үүсэх эрсдэлтэй байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-т "Төрийн албан хаагчид дараахь нөхөх төлбөрийг олгоно", 59.1.1-т "албан томилолтын зардлыг", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралт "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 1.2-т "Төрийн албан хаагчид олгох нөхөх төлбөр дараахь төрөлтэй байна:", 1.2.1-т "албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр", 2.1-т "Төрийн албан хаагчийг гадаад улсад болон нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор өглөө ажилд очих, орой буцах боломжгүй газарт тухайн байгууллага болон дээд шатны удирдах байгууллагаас баталсан удирдамж, төлөвлөгөө, шийдвэрийн дагуу тодорхой хугацаагаар томилон ажиллуулсан нөхцөлд албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр олгоно", 2.5-д "Албан томилолтоор ажиллах төрийн албан хаагчийн байр, хоол, унааны зардлын төсвийг байгууллагын эрх бүхий албан тушаалтан батална", 2.6-д "Албан томилолтоор ажиллах төрийн албан хаагчид томилолтоор ажиллуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр, батлагдсан зардлын төсвийг үндэслэн томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөрийг урьдчилан олгоно", Хөдөлмөрийн дотоод журмын 8.2-т "Албан томилолтоор ажиллах албан хаагч нь Комиссын гишүүн эсвэл Тамгын газрын даргаар батлуулсан ажлын удирдамжтай байна. Тушаал болон удирдамжийг үндэслэн албан хаагчид томилолтын зардлыг тооцож олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан томилолтын зардлын төсвийг эрх бүхий албан тушаалтнаар батлуулж хэвшүүлэх, батлагдсан төсөвт нийцүүлэн санхүүжилтийг олгон гүйцэтгэлд хяналт тавих ажиллах талаар зөвлөмж өгөв.

2. Тайлант хугацаанд мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2020 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн А/19 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсанаас хойш дахин шинэчлэгдээгүй байна. Үүний улмаас тус бодлогын баримт бичгийн хууль, эрх зүйн үндэслэлд одоогоор хүчин төгөлдөр бус болсон эрх зүйн баримт бичгүүдийг ашигласан хэвээр байна. Жишээлбэл:

- Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын хамтарсан 2002 оны 171/111 тоот "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар",
- Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаал "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам",
- Сангийн сайдын 2014 оны 5 дугаар тушаал "Дансны төлөвлөгөө",
- Засгийн газрын 2019 оны 275 дугаар тогтоол "Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай",
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоол "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай",
- Сангийн сайдын 2014 оны 95 дугаар тушаал "Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд мөрдөх журам",
- Сангийн сайдын 2011 оны 132 дугаар тушаал "Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай".

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж,

байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.2.2-т "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах", 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хүний эрхийн Үндэсний Комиссын нягтлан бодох бүртгэлийн бодлогыг баримт бичгийг одоогийн мөрдөгдөж буй хууль тогтоомж, стандарттай нийцүүлэн шинэчлэх талаар зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн Төрийн албаны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль, тогтоомж, журам, зааврын холбогдох заалттай тус тус нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5. Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 3.3 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 24.0 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлэн, 216.9 сая төгрөгийн 5 асуудлаар зөвлөмж өгсөн ба хэрэгжилтийг хянаж, үнэлэхэд 97.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 5. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Төлбөрийн акт	1	3.3	1	3.3	100.0
2	Албан шаардлага	2	24.0	2	24.0	100.0
3	Зөвлөмж	5	216.9	5	206.1	96.3
Нийт дүн		8	244.2	8	233.4	97.7

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, олон жилийн насжилттай авлагыг бүрэн барагдуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 676.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 3.7 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 343.7 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 329.4 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Аудитаар илрүүлсэн 676.8 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 616.6 сая төгрөгөөс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Илрүүлэлт:

Тайлант оны зардлаас түүвэрлэн 5 дугаар сарын цалин тооцоололд горим сорил хэрэгжүүлэхэд албан томилолтоор ажилласан 35 албан хаагчид хоол, унааны нөхөн олговрыг албан томилолтын зардалтай давхардуулан тооцож 2.8 сая төгрөгийг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралт “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам” 2.1-д “Төрийн албан хаагчийг гадаад улсад болон нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор өглөө ажилд очих, орой буцах боломжгүй газарт тухайн байгууллага болон дээд шатны удирдах байгууллагаас баталсан удирдамж, төлөвлөгөө, шийдвэрийн дагуу тодорхой хугацаагаар томилон ажиллуулсан нөхцөлд албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр олгоно.” 2.2-т “Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараахь зардлаас бүрдэнэ”, 2.2.1-д “унааны зардал”, 2.2.2-т “байрны зардал”, 2.2.3-т “хоолны зардал” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Томилолтоор явсан албан хаагчдад хоол, унааны олговор, албан томилолтын зардлыг давхардуулан тооцож олгосон 2.8 сая төгрөгийг нөхөн төлүүлж, улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Илрүүлэлт:

Тайлант онд Тамгын даргын 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А/116 дугаар тушаалаар “Хүний эрхийн төлөө хамтдаа” нээлттэй өдөр арга хэмжээг 2025 оны 10 дугаар сарын 21-ний өдрөөс 28-ны өдрийг хүртэлх хугацаанд Дорноговь аймгийн төв Сайншанд болон Өргөн, Замын-Үүд сумдад хяналт шалгалт хийх, төрийн албан хаагчдад хүний эрхийн сургалт, иргэдтэй уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, томилолтын зардлыг баталсан байна. Тушаалын хүрээнд байгууллагын орон тоонд бүртгэлгүй, “Чайлд лайф медиа” ХХК-ийн захирлын албан томилолтын зардалд 0.8 сая төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын орон тоонд бүртгэлгүй, “Чайлд лайф медиа” ХХК-ийн захирлын албан томилолтын зардалд 0.8 сая төгрөгийг буруутай этгээдээр нөхөн төлүүлж, улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Илрүүлэлт 1:

Тайлант онд 216 иргэн, аж ахуйн нэгжтэй хэвлэл, эх бэлтгэл, хэвлэмэл материал хийх, контент, медиа, олон нийтэд түгээх үйлчилгээ, судалгаа, дүн шинжилгээ, зөвлөх үйлчилгээ, орчуулга, хэлмэрч, синхрон үйлчилгээ, арга хэмжээ, форум, сургалт, уулзалт, аймаг сумдаар явах, машин түрээс, үйлчилгээ, түрээс, засвар, байр ашиглалт, програм хангамж, лиценз, бараа материал, тоног төхөөрөмж, тавилга худалдан авах зорилгоор нийт 3,973.0 сая төгрөгийн гэрээ байгуулсан бөгөөд гэрээний хэрэгжилттэй холбоотой 129.2 сая төгрөгийн дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- Байгуулсан гэрээ болон гэрээ дүгнэсэн актын сар, өдөр зөрүүтэй;
- Нийт 17.5 сая төгрөгийн 3 гэрээнд ажил хүлээлцсэн тайлан, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй;
- Нийт 111.7 сая төгрөгийн 17 гэрээний хугацааг төсвийн жил дамжуулан байгуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 43 дугаар зүйлийн 43.5-д "Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "...бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдээдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," заалтыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг үндэслэн ажил гүйлгээг бүртгэлд тусгаагүй, арга хэмжээг 2 жил дамжуулан хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2:

Өмнөх аудитаар өгсөн "Олон жилийн насжилттай авлагыг шийдвэрлэх арга хэмжээ аваагүй" зөрчилд өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, тайлант оны эцэст ажилчдаас авах авлага 10.8 сая төгрөг, байгууллагаас авах авлага 203.7 сая төгрөг, нийт 214.5 сая төгрөгийн авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 70 дугаар зүйлийн 70.5-д "Төсвийн захирагч тухайн жилийн батлагдсан төсвийг зохистой удирдаагүйн улмаас авлага, өр төлбөр үүсгэсэн нь албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, тайлант оны эцэст шинээр авлага үүсгэсэн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт 1:

Төсвийн санхүүжилт дутуу олгогдсоноос нийт 329.3 сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна. Үүнд:

- Гэрээний дагуу бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт төлөх өглөг 188.1 сая төгрөг;
- Байр ашиглалттай холбоотой түрээсийн төлбөрт төлөх өглөг 1.1 сая төгрөг;
- Бараа үйлчилгээний зардлын өглөг 24.4 сая төгрөг;

Хүний эрхийн Үндэсний Комиссын 2025 оны санхүүгийн тайлан,
Төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

- Хувь хүмүүст төлөх өглөг 98.8 сая төгрөг;
- Ажилчидтай холбоотой цалингийн өглөг 0.14 сая төгрөг, НДШ-ийн өглөг 16.6 сая төгрөг.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;", 70 дугаар зүйлийн 70.5-д "Төсвийн захирагч тухайн жилийн батлагдсан төсвийг зохистой удирдаагүйн улмаас авлага, өр төлбөр үүсгэсэн нь албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийг хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж зарцуулах, он дамжуулан өр төлбөр үүсгэхгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

6.1. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тайлант оны зардлаас түүвэрлэн 5 дугаар сарын цалин тооцоололд горим сорил хэрэгжүүлэхэд албан томилолтоор ажилласан 35 албан хаагчид хоол, унааны нөхөн олговрыг албан томилолтын зардалтай давхардуулан тооцож 2.8 сая төгрөгийг олгосон байна.	1	2,820.0	1	2,820.0				
2	Тайлант онд Тамгын даргын 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А/116 дугаар тушаалаар "Хүний эрхийн төлөө хамтдаа" нээлттэй өдөр арга хэмжээг 2025 оны 10 дугаар сарын 21-ний өдрөөс 28-ны өдрийг хүртэлх хугацаанд Дорноговь аймгийн төв Сайншанд болон Өргөн, Замын-Үүд сумдад хяналт шалгалт хийх, төрийн албан хаагчдад хүний эрхийн сургалт, иргэдтэй уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, томилолтын зардлыг баталсан байна. Тушаалын хүрээнд байгууллагын орон тоонд бүртгэлгүй, Чайлд лайф медиа ХХК-ийн захирлын албан томилолтын зардалд 0.8 сая төгрөгийг олгосон байна.	1	870.0	1	870.0				
3	Өмнөх аудитаар өгсөн "Олон жилийн насжилттай авлагыг шийдвэрлэх арга хэмжээ аваагүй" зөрчилд өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, тайлант оны эцэст ажилчдаас авах авлага 10.8 сая төгрөг, байгууллагаас авах авлага 203.7 сая төгрөг, нийт 214.5 сая төгрөгийн авлага үүсгэсэн байна.	1	214,493.6			1	214,493.6		
4	Тайлант онд 216 иргэн, аж ахуйн нэгжтэй хэвлэл, эх бэлтгэл, хэвлэмэл материал хийх, контент, медиа, олон нийтэд түгээх үйлчилгээ, судалгаа, дүн шинжилгээ, зөвлөх үйлчилгээ, орчуулга, хэлмэрч, синхрон үйлчилгээ, арга хэмжээ, форум, сургалт, уулзалт, аймаг сумдаар явах, машин түрээс, үйлчилгээ, түрээс, засвар, байр ашиглалт, програм хангамж, лиценз, бараа материал, тоног төхөөрөмж, тавилга худалдан авах зорилгоор нийт 3,973.0 сая төгрөгийн гэрээ байгуулсан бөгөөд гэрээний хэрэгжилттэй холбоотой 129.2 сая төгрөгийн дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Байгуулсан гэрээ болон гэрээ дүгнэсэн актын сар өдөр зөрүүтэй; • Нийт 17.5 сая төгрөгийн 3 гэрээнд ажил хүлээлцсэн тайлан, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй; • Нийт 111.7 сая төгрөгийн 17 гэрээний хугацааг төсвийн жил дамжуулан байгуулсан байна. 	1	129,222.6			1	129,222.6		
5	Тайлант онд төсвийн санхүүжилт дутуу олгогдсоноос болон төсвийг зохистой удирдаагүйгээс тайлант оны эцэст нийт 329.3 сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна.	1	329,362.4					1	329,362.4
НИЙТ		5	676,768.6	2	3,690.0	2	343,716.2	1	329,362.4

Хүний эрхийн Үндэсний Комиссын 2025 оны санхүүгийн тайлан,
Төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6.2. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тайлант онд Комиссын даргын баталсан гадаад томилолтын 10, Тамгын газрын даргын баталсан гадаад томилолтын 10, дотоод томилолтын 79, нийт 99 томилолтын тушаал батлагдсан байна. Үүнээс уригч байгууллагын зардлаар 10 томилолт, томилолтын зардлын төсвийг баталсан 18 тушаал, 71 тушаалд томилолтын зардлын төсөв урьдчилан батлагдаагүй байна. Хяналт-шинжилгээнээс үзэхэд албан томилолтын байр, хоол, унааны зардлын төсвийг эрх бүхий албан тушаалтан урьдчилан баталж, батлагдсан төсөвт үндэслэн олгох шаардлагыг хангаагүй, томилолтын зардлын төлөвлөлт, төсвийн сахилга, санхүүжилтийн хяналт сул үр ашиггүй зарцуулалт үүсэх эрсдэлтэй байна.	1	-					1	-
2	Тайлант хугацаанд мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2020 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн А/19 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсанаас хойш дахин шинэчлэгдээгүй байна. Үүний улмаас тус бодлогын баримт бичгийн хууль, эрх зүйн үндэслэлд одоогоор хүчин төгөлдөр бус болсон эрх зүйн баримт бичгүүдийг ашигласан хэвээр байна.	1	-					1	-
НИЙТ		2	-	-	-	-	-	2	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 228/АД111371

Улаанбаатар хот

САГ-2026/25/НА-СТА-ТЭЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны зардлаас түүвэрлэн 5 дугаар сарын цалин тооцоололд горим сорил хэрэгжүүлэхэд албан томилолтоор ажилласан 35 албан хаагчид хоол, унааны нөхөн олговорыг албан томилолтын зардалтай давхардуулан тооцож 2,820,000.00 /хоёр сая найман зуун хорин мянга/ төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралт "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам" 2.1-д "Төрийн албан хаагчийг гадаад улсад болон нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор өглөө ажилд очих, орой буцах боломжгүй газарт тухайн байгууллага болон дээд шатны удирдах байгууллагаас баталсан удирдамж, төлөвлөгөө, шийдвэрийн дагуу тодорхой хугацаагаар томилон ажиллуулсан нөхцөлд албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр олгоно." 2.2-т "Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараахь зардлаас бүрдэнэ", 2.2.1-д "унааны зардал", 2.2.2-т "байрны зардал", 2.2.3-т "хоолны зардал" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн гүйцэтгэл, ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.5-д "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Тайлант оны 5 дугаар сард томилолтоор явсан албан хаагчдад хоол, унааны олговор, албан томилолтын зардлыг давхардуулан тооцож олгосон 2,820,000.00 /хоёр сая найман зуун хорин мянга/ төгрөгийг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч Б.Бадамсэрээжидээр нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь аудитын шалгалтын орлогын 10090000001 тоот дансанд төвлөрүүлэх, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга /Д.Сүнжид/, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч /Б.Бадамсэрээжид/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:
МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



С.МАГНАЙСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 229/АД111371

Улаанбаатар хот

САГ-2026/25/НА-СТА-ТЭЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд

Тайлант онд Тамгын даргын 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А/116 дугаар тушаалаар "Хүний эрхийн төлөө хамтдаа" нээлттэй өдөр арга хэмжээг 2025 оны 10 дугаар сарын 21-ний өдрөөс 28-ны өдрийг хүртэлх хугацаанд Дорноговь аймгийн төв Сайншанд болон Өргөн, Замын-Үүд сумдад хяналт шалгалт хийх, төрийн албан хаагчдад хүний эрхийн сургалт, иргэдтэй уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, томилолтын зардлыг баталсан байна. Тушаалын хүрээнд байгууллагын орон тоонд бүртгэлгүй, "Чайлд лайф медиа" ХХК-ийн захирлын албан томилолтын зардалд 870,000.00 /найман зуун далан мянга/ төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "төрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.5-д "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн", 4.2.3.6-д "эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Байгууллагын орон тоонд бүртгэлгүй, "Чайлд лайф медиа" ХХК-ийн захирлын албан томилолтын зардалд олгосон 870,000.00 /найман зуун далан мянга/ төгрөгийг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч Б.Бадамсэрээгидээр нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкиндахь аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга /Д.Сүнжид/, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч /Б.Бадамсэрээжид/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:
МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1293/А0111371

Улаанбаатар хот

САГ - 2026/25/НА - СТА - ТЭЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 216 иргэн, аж ахуйн нэгжтэй хэвлэл, эх бэлтгэл, хэвлэмэл материал хийх, контент, медиа, олон нийтэд түгээх үйлчилгээ, судалгаа, дүн шинжилгээ, зөвлөх үйлчилгээ, орчуулга, хэлмэрч, синхрон үйлчилгээ, арга хэмжээ, форум, сургалт, уулзалт, аймаг сумдаар явах, машин түрээс, үйлчилгээ, түрээс, засвар, байр ашиглалт, програм хангамж, лиценз, бараа материал, тоног төхөөрөмж, тавилга худалдан авах зорилгоор нийт 3,974,325,603.00 /гурван тэрбум есөн зуун далан дөрвөн сая гурван зуун хорин таван мянга зургаан зуун гурав/ төгрөгийн гэрээ байгуулсан бөгөөд гэрээний хэрэгжилттэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- Байгуулсан гэрээ болон гэрээ дүгнэсэн актын сар, өдөр зөрүүтэй;
- Нийт 17,503,500.00 /арван долоон сая таван зуун гурван мянга таван зуу/ төгрөгийн 3 гэрээнд ажил хүлээлцсэн тайлан, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй;
- Нийт 111,719,082.00 /нэг зуун арван нэгэн сая долоон зуун арван есөн мянга наян хоёр/ төгрөгийн 17 гэрээний хугацааг төсвийн жил дамжуулан байгуулсан байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 43 дугаар зүйлийн 43.5-д "Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "...бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," заалтыг тус тус хэрэгжүүлж ажиллангүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар Байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1-т "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй", 4.2.1.8-д "байгуулсан гэрээ хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй", 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0424 SAG-R Docx

1526182057

1. Анхан шатны баримтыг үндэслэн ажил гүйлгээг бүртгэлд тусгаагүй, төсвийг хоёр жил дамнуулан зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга /Д.Сүнжид/, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч /Б.Бадамсэрээжид/ нарт даалгав.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:



С.МАГНАЙСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1294/АОМ1371

Улаанбаатар хот

САГ - 2026/25/НА - СТА - ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар өгсөн "Олон жилийн насжилттай авлагыг шийдвэрлэх арга хэмжээ аваагүй" зөрчилд өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, тайлант оны эцэст ажилчдаас авах авлага 10,812,133.56 /арван сая найман зуун арван хоёр мянга нэг зуун гучин гурван төгрөг тавин зургаан мөнгө/ төгрөг, байгууллагаас авах авлага 203,681,488.23 /хоёр зуун гурван сая зургаан зуун наян нэгэн мянга дөрвөн зуун наян найман төгрөг хорин гурван мөнгө/ төгрөг, нийт 214,493,621.79 /хоёр зуун арван дөрвөн сая дөрвөн зуун ерэн гурван мянга зургаан зуун хорин нэгэн төгрөг далан есөн мөнгө/ төгрөгийн авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 70 дугаар зүйлийн 70.5-д "Төсвийн захирагч тухайн жилийн батлагдсан төсвийг зохистой удирдаагүйн улмаас авлага, өр төлбөр үүсгэсэн нь албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, тайлант оны эцэст шинээр авлага үүсгэдэг зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга /Д.Сүнжид/, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч /Б.Бадамсэрээжид/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



С.МАГНАЙСҮРЭН